



УУЛ УУРХАЙ, БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ГАМШГААС ХАМГААЛАХ БОЛОН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ, СТАНДАРТ, НОРМ, НОРМАТИВЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨТ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг Улаанбаатар хотоос бусад аймаг, сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга, байгууламжид зохион байгуулж, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2. Хяналт шалгалтад оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3. Хяналт шалгалтыг зохион байгуулах явцдаа Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тавьж байгаа заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөнө.

2.4. Улаанбаатар хотоос бусад аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжуудад хяналт шалгалтыг зохион байгуулна.

2.5. Гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын байцаагчид нь хууль тогтоомж, дүрмээр олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг гүйцэтгэн, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийн хяналт шалгалтаар зөрчил арилаагүй тохиолдолд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл ноогдуулна.

2.6. Шаардлагатай тохиолдолд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхгүйгээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу эрх хязгаарлах, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийтгэл оногдуулах арга хэмжээг авна.

2.7. Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим бүртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

Гурав. Хяналт шалгалт явуулах бүрэлдэхүүн, хугацаа, зардал

3.1. Уул уурхай, баяжуулах үйлдвэрийн барилга байгууламжид хяналт шалгалтыг хийхдээ 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тушаалаар томилон ажиллуулна.

3.2. Хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг Онцгой байдлын газар, хэлтсийн дарга томилон удирдлагаар хангаж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

3.3. Хяналт шалгалт явуулахад шаардлагатай зардлыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

3.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс 07 дугаар сарын 20 өдрийн хооронд тус тус явуулна.

3.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн, мэдээг 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүн, мэдээг 2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн Hyanaltinheltes.obeg@yahoo.com, Гамшгийн шуурхай удирдлагын газрын b.myagmarsuren@nema.gov.mn цахим хаягаар тус тус зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

4.1. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб хуудсанд байршуулж олон нийтэд хүргэнэ.

4.2. Онцгой байдлын ерөнхий газраас хяналт шалгалтын дүн, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

4.3. Төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар, Гамшгийн шуурхай удирдлагын газар тус тус нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, холбогдох яам, агентлаг, газрын дарга нарт улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР